

Монголбанк-нд тайлагнах нь

2021 он 10 сарын 08

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Уламбаярын 2021 оны 3-р улирлын тайлан

Миний бие Баянсангийн Уламбаяр нь өнгөрсөн 2021 оны 3-р улиралд ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр гэрээний дагуу үргэлжлүүлэн ажиллалаа. 2021 оны 7 сард тайлагнаснаас хойш хугацаанд доорх хурлуудад оролцож ажилласан байна.

2021/07/30 ТУЗ-ийн хурал (онлайн)

- ХасБанкны IPO төлөвлөгөөг (“ХасБанк ХХК-г хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах төлөвлөгөө”) МонголБанкны зүгээс өөрчлөлт оруулж дахин хүлээлгэж өгөх чиглэл ирсэн тухай танилцсан.
- Менежментийн оруулсан өөрчлөлтүүдтэй танилцаж, уг шинэчилсэн хувилбарыг МонголБанк-нд хүлээлгэж өгөхийг баталсан.
 - o Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2021/08/25 ТУЗ-ийн хурал (онлайн)

- Өнгөрсөн сарын хугацаан дахь банкны үйл ажиллагаа, менежменттэй холбоотой ерөнхий мэдээлэл авсан. Менежментийн зүгээс дараах сэдвүүдээр бэлдсэн материалын дагуу хурал явагдсан:
 - o “Хасбанк болон групп компаниудын бүтцийн өөрчлөн байгуулалт”. Үүнтэй холбоотой хуулийн фирмээс авсан зөвлөгөө
 - o ХасБанк болон Хас Лизинг компаниудыг нэгтгэх бүтцийн өөрчлөн байгуулалт
 - o ХасБанкны IPO төлөвлөгөөний явц
 - o ХасБанкны IPO-тай холбоотойгоор, банкны дүрмийг шинэчлэх тухай
 - o Банкны 7 сарын үйл ажиллагааны тайлан
- Хурлын дараагаар, цахимаар доорх ТУЗ-ийн шийдвэрүүдийг гаргасан.
 - o ХасБанк болон Хас Лизинг компаниудыг нэгтгэх бүтцийн өөрчлөн байгуулалтын гэрээг батлах.
 - o Тус гэрээг батлахтай холбоотойгоор банкны дүрмийн өөрчлөлтийг батлах.
 - o Банкнаас хувьцаа хэлбэрээр ногдол ашиг тараах хэлбэрээр банкны дүрмийн санг 100 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх.
 - Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2021/09/21 ТУЗ-ийн Аудитын Хорооны Хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: “Ernst&Young аудитын фирмийн, банкны хагас жилийн санхүүгийн тайлан дээрх урьдчилсан байдлаарх хяналт”, “Хүний нөөцийн сургалт, ажилтан хөгжүүлэлтийн процесийн аудит шалгалт”, “Олон улсын банкны гүйлгээний хэлтэсийн аудит шалгалт”, “IT-ийн асуудал, доголдол

шийдвэрлэх менежментийн аудитын тайлан”, “Хамаарал бүхий этгээдүүдийн улирлын тайлан”, ”Банкны хянан нийцүүлэх улирлын тайлан”.

2021/09/21 ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны хурал (онлайн)

- ТУЗ-ийн улирлын ээлжит хурлын дагуу зохион байгуулагдаж, дараах асуудлуудыг хэлэлцсэн: “Эрсдэлийн тайлан”, ”Банкны эрсдэлийн appetite statement”, ”Оны эхний 6 сар дахь, цэвэр хүүгийн орлогод хүүгийн өөрчлөлтийн үзүүлэх нөлөөний sensitivity анализ”, ”1, 2, 3 дахь шатны зээлүүд дээрх IFRS-9 эрсдэлийн сангийн тухай”.
- ”Банкны эрсдэлийн appetite statement”-ний тухайд, тус шинэчлэгдсэн хувилбарыг баталж, ТУЗ-ээр батлуулахаар танилцуулахаар шийдсэн.
 - o Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.

2021/09/21 ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хорооны Хурал (онлайн)

- Ажиглагчаар оролцсон.
- “Компанийн засаглалын тайлан”, “Цалин урамшууллын судалгаа” гэсэн сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлгэ өрнөсөн.

2021/09/22 ТУЗ-ийн ээлжит хурал (онлайн)


- ТУЗ-ийн хороодын хэлэлцэж баталсан шийдвэрүүдийг ТУЗ-ээр баталсан.
 - o Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй.
- Менежментийн зүгээс бэлдсэн дараах асуудлуудтай танилцсан: “ХасБанкны ХК болох үеийн компанийн шинэ дүрмийг бэлдэх”, “ХасБанк болон Хас Лизинг компаниудыг нэгтгэх бүтцийн өөрчлөн байгуулалт”, “IPO төслийн явц”, “Ковид, эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдал”, “Банкны үйл ажиллагааны явцын тайлан”, “IT шинэчлэл, дижитал банкны явц”.
 - o “ХасБанкны ХК болох үеийн компанийн шинэ дүрмийг бэлдэх” асуудлын хүрээнд, ТУЗ-ийн гишүүдийн томилгоо, сонгон шалгаруулалтыг явуулах аргачлалын талаар СЗХ-ны зааварчилгааг танилцуулсан.
 - o “Банкны үйл ажиллагааны явцын тайлан” асуудлын хүрээнд, ПОС машины гүйлгээний хэмжээ, шимтгэлийн дата, нэгтгэлийг сонсож, цаашид нэмэлт анализ хийх талаар ярилцсан.
 - o “IT шинэчлэл, дижитал банкны явц” асуудлын хүрээнд, шинээр гаргасан Corporate / Tablet banking талаар ярилцан, уг бүтээгдэхүүн нь өөр вендороос авж хэрэгжүүлж буй I-Exceed системээс тусдаа хөгжүүлэгдэж байгааг танилцуулсан.

Банкны засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагаа

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байна. Хувь нийлүүлэгч, ТУЗ ба удирдлагын багийн хоорондох мэдээлэх процес, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу ажиллаж байна.

ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны ба түүний харилцагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа холбогдох хууль журмыг зөрчсөн ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүй.

Хүндэтгэсэн,



Б. Уламбаяр

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн